

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРХИВЫН ТАСАГ**

**(Лавлагаа хүсэгчдэд зориулсан
товч лавлах)**

Арвайхээр. Д.Пүрэвдоржийн
гудамж 301, Аймгийн архивын байр
Утас:7032-2261

2018 он

Аймгийн архивын тасаг нь байгууллага, иргэдийн хүсэлтээр хадгаламжийн сангийн баримтаас доорх асуудлаар лавлагаа хуулбар олгох бөгөөд уншлагын танхимаар судлуулна. Үүнд:

1. Ам бүлийн тодорхойлолт, төрсөн он, нас
2. Ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн, шагнагдсан тухай хуулбар
3. Цалингийн тодорхойлолт, ажиллаж байсныг нотлох баримтын лавлагаа
4. Гэрчилгээ, аттестатын хуулбар
5. Тухайн байгууллага, салбар, нэгжийн түүхэн танилцуулга
6. Барилгын зураг, төсөв, ашиглалтад оруулсан акт, дүгнэлт, бусад
7. “Алдарт-Эх”-ийн одонгоор шагнагдсан тухай
8. Өмч хувьчлалтай холбоотой асуудлаарх хуулбар, лавлагаа

Манайхаар үйлчлүүлэхийг хүссэн та ямар асуудлаар лавлагаа хуулбар авах тухайгаа архиваас олгох захиалгын хуудсанд загварын дагуу тодорхой бичих, уншлагын танхимаар үйлчлүүлэх анкет бөглөх шаардлагатай.

Архивын Ерөнхий газрын даргын 2015 оны А/168 Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифт зааснаар лавлагаа, хуулбарын үнийг Төрийн сан аймгийн ЗДТГазрын **100051001** дансанд төлбөрийг тушаана.

Та доорхи материалыг бүрдүүлж ирвэл та бидний ажил хөнгөн шуурхай бүтэмжтэй болно.

Нэг: Хүн амын тооллогын баримтуудаас лавлагаа, хуулбар олгоход шаардагдах баримт.

а) Иргэний үнэмлэх

б) Гэрлэлтийн баталгаа

в) Тухайн үед засаг захиргааны ямар нэгжид амьдарч байсан, өрхийн тэргүүний овог нэр тодорхой байх.

(1929.1944.1956.1966.1989.2000 онуудад)

Хоёр: Байгууллагын даргын тушаалын баримтуудаас лавлагаа хуулбар олгоход шаардагдах баримт: **а)** Иргэний үнэмлэх

б) Хөдөлмөрийн дэвтэр

в) Нийгмийн даатгалын дэвтэр

Гурав: Одон медаль болон “Алдарт-Эх”-ийн одонгийн лавлагаа, хуулбар олгоход шаардагдах баримт:

а) Аймаг, сум, овог нэр тодорхой байх

б) Одон авсан огноо

(5.8 дахь хүүхдийн төрсөн оныг тодорхойлох нотлох баримт)

Дөрөв: Татан буугдсан болон хувьчлагдсан байгууллагын цалингийн тодорхойлолтын лавлагаа, хуулбар олгоход шаардагдах бичиг баримт

а) Иргэний үнэмлэх

б) Гэрлэлтийн баталгаа

в) Хөдөлмөрийн дэвтэр

г) Нийгмийн даатгалын дэвтэр

Тав: Банкны баримтаас лавлагаа, хуулбар олгоход шаардагдах баримт:

а) Иргэний үнэмлэх

б) Банкны байгууллагуудын албан бичиг

Зургаа: Нотариатын баримтаас лавлагаа, хуулбар олгоход шаардагдах бичиг

а) Иргэний үнэмлэх

б) Баталгаажуулсан нотариатчийн зөвшөөрсөн албан бичиг

Долоо: Эрүүгийн хавтаст хэргийн баримтуудаас

а) Улсын дээд шүүхийн албан бичиг б) Улсын Ерөнхий Прокурорын газрын албан бичиг

в) Шүүх, Цагдаагийн байгууллагын албан бичиг

Найм: Иргэний хавтаст хэргийн баримтуудаас

а) Хариуцагч, нэхэмжлэгчийн хувийн өргөдөл